

**РЕМИКОН ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026.04.30

№ ХЭХ-26/01

Улаанбаатар хот

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Ремикон ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6.11, Ремикон ХК-ийн 2026 оны 4-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэр зэргийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

2025 оны санхүүгийн болон үйл
ажиллагааны тайланг батлах тухай

1. Ремикон ХК-ийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 2 дугаар сарын 23-ний өдрийн дугаар 26/2/1 тоот дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЭРДЭНЭБАЯР

**РЕМИКОН ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026.04.30

№ ХЭХ-26/02

Улаанбаатар хот

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, Ремикон ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6.7, Ремикон ХК-ийн 2026 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, 2026 оны 04-р сарын 30-ны өдрийн Ремикон ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Төлөөлөн удирдах зөвлөлийн
 гишүүнээр томилох тухай

1. Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат гишүүнээр Х.Гантулга, Б.Батсайхан, Х.Хашчимэг, Ч.Дагийжанчив, Ц.Эрдэнэбаяр, Э.Мөнхсайхан нарыг, хараат бус гишүүнээр С.Баянмөнх, Д.Алтанхуяг, С.Дөлгөөн нарыг 2026 оны 4-р сарын 30-ны өдрөөс 2027 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох хүртэл хугацаагаар тус тус томилсугай.

2. Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд зохих журмын дагуу цалин, хангамжийг бодож олгохыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЭРДЭНЭБАЯР

**РЕМИКОН ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026.04.30

№ ХЭХ-26/03

Улаанбаатар хот

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, Ремикон ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6.7, Ремикон ХК-ийн 2026 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн Цалин урамшууллын хорооны шийдвэр, Ремикон ХК-ийн 2026 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, 2026 оны 04-р сарын 30-ны өдрийн Ремикон ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Төлөөлөн удирдах зөвлөлийн
Төсөв батлах тухай

1. Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, хараат гишүүн, хараат бус гишүүн, нарийн бичгийн дарга нарт цалин бодох нөхцөл, цалингийн хэмжээг Ремикон ХК-ийн 2026 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын Дугаар 26/2/8 тогтоолын дагуу тооцож олгохыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын дагуу цалин, хангамжийг бодож олгохыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЭРДЭНЭБАЯР